



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум 2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](mailto:erdenebaatar@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinhorloog@audit.gov.mn](mailto:ichinhorloog@audit.gov.mn)  
Аудитор: Л.Мөнх-Оргил  
Утас: 99039344 Цахим хаяг: [munkh-Orgill@audit.gov.mn](mailto:munkh-Orgill@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/100  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Р.МАШБАТ  
ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 864,192.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 192,149.6 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийн зориулалт бус зарцуулалттай холбоотой 859.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 160,151.5 мянган төгрөгийн 4 зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 31,138.3 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүллээ.

## **Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нь аймгийн Засаг даргаар батлуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 99.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>476,516,772.28</b>	<b>1,086,780,041.83</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>00.00</b>	<b>996,000.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>00.00</b>	<b>996,000.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>00.00</b>	<b>996,000.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	996,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>100,707,968.62</b>	<b>375,076,636.50</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,707,968.62	126,275,041.16
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	203,257,305.34
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>45,544,290.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	45,544,290.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>375,808,803.66</b>	<b>710,707,405.33</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>361,488,803.66</b>	<b>701,947,405.33</b>
35410	Бичиг хэргийн материал	00.00	585,000.00
35420	Аж ахуйн материал	237,226,003.66	664,536,805.33
35440	Түлш, шатах тослох материал	18,610,000.00	10,300,000.00
35450	Барилгын засварын материал	6,231,600.00	4,458,100.00
35470	Бусад хангамжийн материал	99,421,200.00	22,067,500.00
35600	Мал амьтад	14,320,000.00	8,760,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,998,830,979.45</b>	<b>4,385,299,641.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,998,830,979.45</b>	<b>4,385,299,641.61</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,608,598,579.45</b>	<b>4,057,288,241.57</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,956,693,995.00	2,956,693,995.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-254,771,986.68	-304,050,219.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	538,616,501.08	800,196,952.08
39204	Хуримтлагдсан элэгдэл	-152,108,994.64	-305,586,493.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	531,715,680.00	1,052,158,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-198,347,281.07	-306,952,994.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	249,623,493.00	263,583,493.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-116,649,477.78	-153,645,892.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	119,687,023.00	139,461,064.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-65,860,372.46	-84,570,341.79
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>390,232,400.00</b>	<b>328,011,400.04</b>
39301	Програм хангамж	10,880,000.00	10,880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,625,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	379,352,400.00	319,757,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,475,347,751.73</b>	<b>5,472,079,683.44</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,469,500.00</b>	<b>4,489,671.19</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,469,500.00</b>	<b>4,489,671.19</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>4,469,500.00</b>	<b>4,489,671.19</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>4,469,500.00</b>	<b>4,489,671.19</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	4,469,500.00	4,489,671.19
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,470,878,251.73</b>	<b>5,467,590,012.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,470,878,251.73</b>	<b>5,467,590,012.25</b>

**Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,200,644,021.65	1,200,644,021.65
51101	Өмч: - төрийн	1,200,644,021.65	1,200,644,021.65
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>686,953,967.73</b>	<b>1,683,665,728.25</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	686,953,967.73	686,953,967.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	996,711,760.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,583,280,262.35	2,583,280,262.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,475,347,751.73</b>	<b>5,472,079,683.44</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>11,075,298,389.00</b>	<b>12,346,762,676.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>765,401,510.00</b>	<b>2,329,013,033.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	765,401,510.00	2,329,013,033.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	765,401,510.00	2,329,013,033.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,281,710.00	7,706,034.28
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	732,559,800.00	864,191,999.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	24,560,000.00	1,457,115,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,309,896,879.00</b>	<b>10,017,749,643.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	174,846,179.00	744,038,593.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,731,179.00	744,038,593.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,115,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,135,050,700.00	9,273,711,050.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,135,050,700.00	9,273,711,050.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,366,146,700.45</b>	<b>10,412,545,370.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,366,146,700.45</b>	<b>10,412,545,370.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,502,658,128.57	9,638,137,227.84
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,743,279,210.28	3,180,566,221.41
210101	Үндсэн цалин	1,424,535,164.74	1,655,770,502.05
210102	Нэмэгдэл	968,593,433.03	1,107,301,092.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	172,254,065.91	172,908,988.83
210104	Урамшуулал	132,179,550.00	182,835,459.17
210105	Гэрээт ажлын хөлс	45,716,996.60	61,750,178.83
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	332,851,368.90	396,680,208.62
210201	Тэтгэврийн даатгал	231,882,405.44	272,613,661.49
210202	Тэтгэмжийн даатгал	24,905,932.39	29,979,373.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,940,074.09	16,157,253.35
210204	Ажилгүйдлийн даатгал	12,225,139.68	14,660,659.16
210205	Эрүүл мэндийн даатгал	50,897,817.30	63,269,261.56

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

**Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	301,546,102.98	514,223,808.51
210301	Гэрэл, цахилгаан	14,485,397.26	24,267,467.72
210302	Түлш, халаалт	271,256,989.22	470,345,002.37
210303	Цэвэр, бохир ус	15,803,716.50	19,611,338.42
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	271,666,608.00	591,886,835.22
210401	Бичиг хэрэг	56,523,940.00	38,352,900.00
210402	Тээвэр, шатахуун	147,564,880.00	204,322,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,785,873.00	15,226,160.22
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,067,000.00	1,740,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,724,915.00	44,940,720.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	169,785,000.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	117,519,555.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	1,718,300.00
210502	Хоол, хүнс	00.00	1,718,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	106,470,690.00	72,246,780.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	106,470,690.00	71,946,780.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	180,433,600.00	182,280,100.00
210702	Дотоод албан томилолт	148,123,600.00	142,269,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	32,310,000.00	40,010,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,051,188,943.85	2,734,660,478.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,026,083,575.85	2,720,392,476.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,880,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,408,975.00	4,050,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	429,526.00	397,494.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,657,300.00	6,723,000.00
210807	Газрын төлбөр	3,641,567.00	2,976,508.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,515,221,604.56	1,963,874,495.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,312,062,883.22	1,532,252,044.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,454,660.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	200,704,061.34	431,622,451.29
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,863,488,571.88	774,408,143.04
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,812,582,080.36	464,794,781.32
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	39,765,300.00	40,999,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,094,200.00	81,510,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	58,277,109.30
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,652,459.36	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	183,125,222.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,665,070,121.00	100,882,750.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,050,906,491.52	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,050,906,491.52	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	309,613,361.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	309,613,361.72
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>709,151,688.55</b>	<b>1,934,217,305.40</b>

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	448,152,311.30	937,505,544.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	156,265,311.30	112,600,785.55
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	291,887,000.00	824,904,759.33
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-448,152,311.30	-937,505,544.88
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>260,999,377.25</b>	<b>996,711,760.52</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>10,318,178,589.00</b>	<b>10,025,455,677.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,281,710.00</b>	<b>7,706,034.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,281,710.00	7,706,034.28
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	8,281,710.00	7,706,034.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,281,710.00	7,706,034.28
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,309,896,879.00</b>	<b>10,017,749,643.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	174,846,179.00	744,038,593.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,731,179.00	744,038,593.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,115,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,135,050,700.00	9,273,711,050.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,135,050,700.00	9,273,711,050.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>10,206,803,089.00</b>	<b>9,957,959,777.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,206,803,089.00</b>	<b>9,957,959,777.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,455,497,141.12</b>	<b>8,932,971,438.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,803,861,481.17	3,194,417,561.25
210101	Үндсэн цалин	1,485,117,435.63	1,669,621,841.89
210102	Нэмэгдэл	968,593,433.03	1,107,301,092.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	172,254,065.91	172,908,988.83
210104	Урамшуулал	132,179,550.00	182,835,459.17
210105	Гэрээт ажлын хөлс	45,716,996.60	61,750,178.83
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	332,851,368.90	396,408,375.27
210201	Тэтгэврийн даатгал	231,882,405.44	272,613,661.49
210202	Тэтгэмжийн даатгал	24,905,932.39	29,979,373.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,958,220.09	16,157,253.35
210204	Ажилгүйдлийн даатгал	12,206,993.68	14,660,659.16
210205	Эрүүл мэндийн даатгал	50,897,817.30	62,997,428.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	301,546,102.98	556,341,452.16
210301	Гэрэл, цахилгаан	14,485,397.26	20,840,821.37
210302	Түлш, халаалт	271,256,989.22	515,889,292.37
210303	Цэвэр, бохир ус	15,803,716.50	19,611,338.42

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

**Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	234,880,814.00	227,284,780.22
210401	Бичиг хэрэг	46,641,840.00	34,471,100.00
210402	Тээвэр, шатахуун	98,826,000.00	118,032,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,785,873.00	15,191,160.22
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,067,000.00	1,900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,560,101.00	57,690,020.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	11,752,400.00	17,069,000.00
210502	Хоол, хүнс	00.00	1,802,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,752,400.00	15,267,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	93,607,490.00	84,744,937.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	10,198,900.00
210602	Тавилга	3,153,800.00	00.00
210604	Урсгал засвар	90,453,690.00	74,546,037.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	180,433,600.00	194,089,600.00
210702	Дотоод албан томилолт	148,123,600.00	143,549,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	32,310,000.00	50,540,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,263,541,775.85	3,085,783,020.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,236,181,407.85	3,055,659,818.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,880,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,408,975.00	4,050,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	429,526.00	397,494.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,912,300.00	22,811,000.00
210807	Газрын төлбөр	3,641,567.00	2,743,708.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,233,022,108.22	1,176,832,711.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,230,567,448.22	1,176,832,711.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,454,660.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,751,305,947.88</b>	<b>1,024,988,339.08</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,700,399,456.36	512,117,672.02
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	39,765,300.00	59,359,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,094,200.00	95,910,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	57,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,652,459.36	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	183,125,222.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,552,887,497.00	116,622,750.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,050,906,491.52	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,050,906,491.52	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	512,870,667.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	512,870,667.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>111,375,500.00</b>	<b>67,495,900.00</b>

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	111,375,500.00	66,499,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	111,375,500.00	66,499,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	111,375,500.00	66,499,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	111,375,500.00	66,499,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-111,375,500.00	-66,499,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	996,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	996,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,586,826,568.53	519,899,374.96	4,459,187,465.14
C07	Тайлант үеийн үр дүн	-151,817,500.00	00.00	6,832,619,543.92	109,181,877.25
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,644,021.65	2,583,280,262.35	7,352,518,918.88	4,470,878,251.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,200,644,021.65	2,583,280,262.35	686,953,967.73	4,470,878,251.73
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	996,711,760.52	996,711,760.52
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,644,021.65	2,583,280,262.35	1,683,665,728.25	5,467,590,012.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,970,042,400.00	8,971,803,722.56	998,238,677.44	90.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,970,042,400.00	8,971,803,722.56	998,238,677.44	90.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,318,604,800.00	8,463,001,050.54	855,603,749.46	90.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,278,468,800.00	3,132,667,382.42	145,801,417.58	95.6
210101	Үндсэн цалин	1,588,215,100.00	1,669,621,841.89	-81,406,741.89	105.1
210102	Нэмэгдэл	1,210,408,300.00	1,107,301,092.53	103,107,207.47	91.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	192,018,600.00	172,908,988.83	19,109,611.17	90.0
210104	Урамшуулал	287,826,800.00	182,835,459.17	104,991,340.83	63.5

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	409,808,600.00	390,141,768.18	19,666,831.82	95.2
210201	Тэтгэврийн даатгал	278,669,900.00	268,310,833.59	10,359,066.41	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	32,784,700.00	29,500,345.22	3,284,354.78	90.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,392,300.00	15,887,552.85	504,747.15	96.9
210204	Ажилгүйдлийн даатгал	16,392,300.00	14,412,170.24	1,980,129.76	87.9
210205	Эрүүл мэндийн даатгал	65,569,400.00	62,030,866.28	3,538,533.72	94.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	553,210,600.00	555,841,452.16	-2,630,852.16	100.5
210301	Гэрэл, цахилгаан	19,800,000.00	20,340,821.37	-540,821.37	102.7
210302	Түлш, халаалт	511,989,600.00	515,889,292.37	-3,899,692.37	100.8
210303	Цэвэр, бохир ус	21,421,000.00	19,611,338.42	1,809,661.58	91.6
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	260,749,900.00	226,394,580.22	34,355,319.78	86.8
210401	Бичиг хэрэг	44,090,600.00	34,471,100.00	9,619,500.00	78.2
210402	Тээвэр, шатахуун	125,141,300.00	117,532,500.00	7,608,800.00	93.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,958,000.00	14,916,160.22	1,041,839.78	93.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	1,900,000.00	2,100,000.00	47.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,560,000.00	57,574,820.00	13,985,180.00	80.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,267,000.00	15,267,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,267,000.00	15,267,000.00	00.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	175,576,600.00	140,305,037.00	35,271,563.00	79.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,500,000.00	50,360,000.00	140,000.00	99.7
210602	Тавилга	19,500,000.00	15,615,000.00	3,885,000.00	80.1
210604	Урсгал засвар	105,576,600.00	74,330,037.00	31,246,563.00	70.4
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	233,232,500.00	194,089,600.00	39,142,900.00	83.2
210702	Дотоод албан томилолт	156,832,500.00	143,549,200.00	13,283,300.00	91.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	76,400,000.00	50,540,400.00	25,859,600.00	66.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,285,140,500.00	3,085,783,020.56	199,357,479.44	93.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	3,250,690,500.00	3,055,659,818.56	195,030,681.44	94.0

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	00.00	1,440,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,050,000.00	4,050,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	397,494.00	2,506.00	99.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	121,000.00	79,000.00	60.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,060,000.00	22,811,000.00	2,249,000.00	91.0
210807	Газрын төлбөр	3,300,000.00	2,743,708.00	556,292.00	83.1
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1107150300.00</b>	<b>722511210.00</b>	<b>384,639,090.00</b>	<b>65.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,105,150,300.00	722,511,210.00	382,639,090.00	65.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	00.00	2,000,000.00	0.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>651437600.00</b>	<b>508802672.02</b>	<b>142,634,927.98</b>	<b>78.1</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>651,437,600.00</b>	<b>508,802,672.02</b>	<b>142,634,927.98</b>	<b>78.1</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	60,000,000.00	59,359,000.00	641,000.00	98.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	83,000,000.00	95,910,700.00	-12,910,700.00	115.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,100,000.00	57,100,000.00	00.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	315,137,600.00	183,125,222.02	132,012,377.98	58.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	136,200,000.00	113,307,750.00	22,892,250.00	83.2
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,970,042,400.00</b>	<b>8,971,803,722.56</b>	<b>998,238,677.44</b>	<b>90.0</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>9,962,042,400.00</b>	<b>8,964,097,688.28</b>	<b>997,944,711.72</b>	<b>90.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	9,962,042,400.00	8,964,097,688.28	997,944,711.72	90.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,000,000.00</b>	<b>7,706,034.28</b>	<b>293,965.72</b>	<b>96.3</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	7,706,034.28	293,965.72	96.3
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>77.00</b>	<b>77.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>

**Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

620001	Удирдах ажилтан	11.00	11.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	00.00	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>725,738,593.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>725,738,593.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	519,166,287.66
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	50,546,178.83
210105	Гэрээт ажлын хөлс	50,546,178.83
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,266,607.09
210201	Тэтгэврийн даатгал	4,302,827.90
210202	Тэтгэмжийн даатгал	479,027.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	269,700.50
210204	Ажилгүйдлийн даатгал	248,488.92
210205	Эрүүл мэндийн даатгал	966,561.93
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	890,200.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	115,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,802,000.00
210502	Хоол, хүнс	1,802,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,055,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,839,800.00
210604	Урсгал засвар	216,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	454,105,501.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	454,105,501.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	331,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,315,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,315,000.00
<b>2135</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>203,257,305.34</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	203,257,305.34
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	725,738,593.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	725,738,593.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	725,738,593.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>17,304,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>17,304,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	17,304,000.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	11,204,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,204,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6100000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,100,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	18,300,000.00
<b>1311</b>	<b>Ахмадын дансны орлого</b>	18,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,300,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
201	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	996,000.00

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдаа илрээгүй.

Аудитаар нийт 192,149.6 мянган төгрөгийн 10 зөрчил илэрснээс 859.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 160,151.6 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгч, 31,138.3 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт хүргүүлсэн.

### 3.2 Төлбөрийн акт

#### 1. Төсвийн зарцуулалттай холбоотой

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 420.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7 "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

1. Аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 439.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авч төсвийн үр ашгийг бууруулсан байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно" 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохисой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

### 3.3 Албан шаардлага

#### 1. Төсвийн зарцуулалттай холбоотой

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Должинсорогдогийг "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн дагуу суралцуулахаар шийдвэрлэж суралцаж байх хугацаанд нь 33,000.0 мянган төгрөгийг суралцаж байх хугацаанд нь орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаагийн тэтгэмжийг аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Б/14 дүгээр захирамжаар олгосон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн А/457 дугаар захирамжийн хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг баримталсан эсэхийг тулгаж үзэхэд дараах нөхцөл байдал илэрлээ. Үүнд:

1. Тухайн албан хаагчийг суралцуулах талаар аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй,

2. Албан хаагч нь суралцаж төгссөний дараа тухайн байгууллагадаа ямар хугацаагаар үргэлжлүүлэн ажиллах эсэх нь тодорхойгүй,

3. Албан хаагч дээрх хөтөлбөрийн хүрээнд суралцсанаар хүрэх үр дүн нь тодорхойгүй,

4. Тус албан хаагч аймгийн худалдан авах ажиллагааны газраас өөр байгууллагад шилжин ажилласан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 "мэргэшсэн, тогтвортой байх зарчим, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн А/457 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр"-ын 3.1.2 "Бодитой, үр дүн нь тодорхой байх", захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан "ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн 3.2 "... хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан баталж байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох журмын дагуу тайлагнана", 5.4. "Төрийн албан хаагчийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулах чиглэл"-тэй тус тус нийцэхгүй байна.

2. Тэтгэмж урамшууллын зардлаас албан хаагчдад 66,400.0 мянган төгрөгийн хууль тогтоомжоор заагдаагүй дэмжлэг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно" 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Тус байгууллага нь тайлант онд гадаад улсад уулзалт арга хэмжээнд оролцоход зарцуулах 19,277.5 мянган төгрөгийг хувь хүний дансаар дамжуулан бэлнээр гаргаж анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шууд зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой**

1. Тус байгууллага нь Төсвийн хөрөнгөөр байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагагүй 41,474.0 төгрөгийн материал бэлтгэн зарцуулж төсвийн үр ашгийг бууруулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно” 12.1.4-т “*хуулиар зөвшөөрөөгүй бусад*”, 15.1.6-т “төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: *нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*” гэж заасантай тус тус нийцэхгүй, “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрэлт: Дээрх зөрчлүүдэд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулбал: Үүнд:

#### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой**

##### **1.1 Илрүүлэлт:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4 дүгээр улиралд зарцуулсан шатахуунаас 20,440.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтыг түүвэрлэн хяналт хэрэгжүүлэхэд жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогчоор бодуулж, холбогдох албан хаагчаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно*” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Жолоочийн тооцоог тухай бүр бодож, шатахуун зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх

##### **2.1 Илрүүлэлт:**

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь байгууллагын үндсэн цалингийн зардлаас ЗДТГ-ын дэргэдэх Теле хяналтын төвийн албан хаагчдад 10,698.3 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг*

үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх

**3. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэй холбоотой**

**3.1 Илрүүлэлт:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогчийн албан үүргийг ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогчоор хавсран гүйцэтгүүлж байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

**3.2 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодогчийг хууль тогтоомжид нийцүүлэн томилох;

**4.Дотоод хяналт хариуцлагатай холбоотой**

**4.1 Илрүүлэлт**

Байгууллагын дотоод хяналтын нэгж нь тайлант онд 7 ажил хийхээр төлөвлөсөн боловч 2 ажилд хяналт хэрэгжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.3 “ дотоод хяналт шалгалтыг удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино” гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2 Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын дотоод хяналтын нэгжийг журмын дагуу ажиллуулах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ  
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруул аагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		

**Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

<b>Дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		
------------	----------	----------	----------	----------	----------	----------	----------	----------	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн	2	41,913.0	1	439.0	1	41,474.0						
Хууль тогтоомжид нийцээгүй дэмжлэг, тэтгэмж олгосон	2	99,400.0			2	99,400.0						
Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүйгээр Хувь хүний дансаар дажуулан төсөв зарцуулсан.	1	19,277.5			1	19,277.5						
Сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосн	1	420.8	1	420.8								
Жолоочийн тооцоо дутуу бодсон	1	20,440.0					1	20,440.0				
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн	1	10,698.3					1	10,698.3				
Дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүй	1	0					1	0				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>192,149.6</b>	<b>2</b>	<b>59.8</b>	<b>4</b>	<b>160,151.5</b>	<b>3</b>	<b>31,138.3</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Аудитын код: ХӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

ЗДТГ-ын нягтлан бодогчийн албан үүргийг ТЕЗ-ийн нягтлан бодогчоор хавсран гүйцэтгүүлсэн	1	0					1	0
<b>Дүн</b>	1	0					1	0